

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ

ETT

# “ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ” БОНДЫН ТАНИЛЦУУЛГА

2021 он

БиДиСЕК ҮЦК ХК

Андеррайтер, Брокер, Хөрөнгө оруулалтын зөвлөх

MICC

# САНАМЖ

ҮНЭТ ЦААСЫГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

# АГУУЛГА


1 Бонд гаргагчийн тухай

2 Санхүүгийн хураангуй мэдээлэл

3 Бондын нөхцөл

4 Бонд гаргагчийн зах зээлийн төлөв байдал

5 Бонд гаргагчийн хөгжлийн төлөвлөгөө

6 Хавсралт

# ХУРААНГУЙ

**Ерөнхий мэдээлэл**

- Эрдэнэс Тавантолгой ХК (цаашид **ЭТТ** эсвэл **Бонд гаргагч** гэх) нь Монголын топ 5 компанийн нэг бөгөөд стратегийн ач холбогдол бүхий Тавантолгой нүүрсний орд газарт ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг хаалттай хувьцаат компани юм.
- ЭТТ нь 2021-2025 онд хэрэгжүүлэх бизнесийг өргөжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай нэмэлт санхүүжилтийг татахын тулд **600,000,000,000** /зургаан зуун тэрбум / төгрөгийн үнийн дүнтэй бонд гаргаж байгаа ба, үүний 120 тэрбум төгрөгтэй тэнцэхүйц хэсгийг төгрөгийн бондоор, 168 сая ам.долларыг (480 тэрбум төгрөгтэй тэнцэхүйц) ам.долларын бондоор олон нийтэд санал болгож байна.
- Бондын нөхцлүүд: Төгрөгийн бондын жилийн хүү **10%** хүртэл, долларын бондын жилийн хүү **6.8%** хүртэл, 2 жилийн хугацаатай, хүүг хагас жил тутам олгоно.

**Зах зээлд эзлэх байр суурь**

- ЭТТ нь бүрэн ашиглагдаагүй байгаа коксжих нүүрсний дэлхийн хэмжээний нөөцтэй ордыг эзэмшигч бөгөөд дэлхийн коксжих нүүрсний нийлүүлэлтийн 5.1%-ийг бүрдүүлдэг.
- Бонд гаргагч нь 2021 онд дэлхийн коксжих нүүрсний борлуулалтын 7%, **2023 онд 10.3%**-ийг (31.9 сая тонн) бүрдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

**Хөрөнгийн зарцуулалт**

- ЭТТ нь төвлөрүүлсэн **600,000,000,000 (зургаан зуун тэрбум төгрөг)**-ийг ЭТТ-ээс хэрэгжүүлж буй дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэхэд зарцуулна.
- Жилийн дундаж олборлолтыг 2025 он хүртэл үе шаттайгаар нэмэгдүүлж, **50 сая тонн**-д **хүргэнэ.** Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, борлуулалтын орлогыг нэмэгдүүлнэ.

**Санхүүгийн мэдээлэл**

- 2011 онд ЭТТ үйл ажиллагааны эхний үед **26.6 тэрбум төгрөг**ийн борлуулалтын орлого олж байсан бол үйл ажиллагаагаа өргөжүүлж амжилттай ажилласны үндсэнд борлуулалтын орлого нь жилд дунджаар 57 хувиар өсөж 2020 оны байдлаар борлуулалтын орлого нь **1.5 их наяд** төгрөгт хүрчээ.
- ЭТТ нь 2021 онд 21 сая тонн нүүрс борлуулж, 2.7 их наяд төгрөгийн борлуулалтын орлого, 514 тэрбум төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөж байна.
- ЭТТ нь өр төлбөрөө барагдуулах зохистой харьцааг хангаж байна: Өр/ХТЭХӨА - 0.34, Өр/Эздийн Өмч - 7%

# БОНД ГАРГАГЧИЙН ТУХАЙ

## ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК





## ГАРГАСАН АМЖИЛТУУД

**ААНОАТ хамгийн их татвар ногдуулж, тайлагнасан компани** /2019 он/

Top 100
**Монгол Улсын топ-100 компанийн 2т гурван жил дараалан жагссан**

**Хөрөнгө болон ашгийн хэмжээгээр №1 жагсдаг**

*Эх сурвалж: МҮХАҮТ, Татварын ерөнхий газар*

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ

| Монгол Улсын Засгийн Газар | 2.5 сая иргэд | Дотоодын ААН |
|---|---|---|
| 81.51% | 18.44% | 0.06% |

*Эх сурвалж: ЭТТ*

## ТҮҮХЭН ЗАМНАЛ

**2010**
ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ
ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ ХК Эрдэнэс Монгол ХХК-н охин компани хэлбэрээр байгуулагдсан

**2011**
Цанхийн зүүн уурхайн ТЭЗҮ-г батлуулан, **олборлолтын үйл ажиллагаа** эхлүүлсэн

**2012**
1072 хувьцаа
Монгол Улсын 2.5 сая иргэдэд **1,072 ширхэг** хувьцааг эзэмшүүлсэн

**2016**
Уурхайн үйл ажиллагаа эхэлснээс хойш олборлосон нүүрсний хэмжээ **20 сая тонн** хүрсэн

**2019**
Борлуулалтын орлого
**₮ 2.66 их наяд**
Цэвэр ашиг
**₮ 1 их наяд** хүрсэн

**2020**
Нийт хувьцаа эзэмшигч иргэдэд **₮ 180 тэрбумын** ногдол ашиг хуваарилсан

КОМПАНИЙН ҮНЭ ЦЭН

# БОНД ГАРГАГЧИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ОРДУУДЫН НӨӨЦ

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ЕТТ

## ОРДЫН ТУХАЙ




## НӨӨЦИЙН ТУХАЙ

**Нийт талбайн хэмжээ**: 68.3 мян.га

**Нийт нүүрсний нөөц**: 6.31 тэр.тн

***Нүүрсний нөөц, төрлөөр***




***Цанхийн нүүрсний нөөц, нөөцийн ангиллаар***




*Эх сурвалж: ЭТТ*

## ОЛБОРЛОЛТЫН ТУХАЙ

**Нийт нүүрс олборлолт**: 69.5 сая тонн




*Нийт олборлосон нөөц, давхраасаар /2010-2020/*

| Нүүрс | Нийт | Хувь |
|---|---|---|
| Сайн чанарын хатуу чанартай | 67.1 | 96.5% |
| Зөөлөн коксжих чанартай, исэлдсэн, баяжуулсан нүүрс | 0.44 | 3.5% |
| **69.5** сая. тонн | | |

*ЭТТ нь Монголын хамгийн том нүүрсний ордын эзэмшигч бөгөөд орд нь нийт 7 тэрбум тонн нөөц бүхий дэлхийн хамгийн том бүрэн ашиглагдаагүй нүүрсний орд юм.*

*Эх сурвалж: Компанийн бизнес төлөвлөгөө*

# **БОНД ГАРГАГЧИЙН** САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ МЭДЭЭЛЭЛ

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ЕТТ

- ЭТТ нь 2019 оны байдлаар үйл ажиллагаа өргөжүүлж, төсөл хөтөлбөрүүдийг эрчимжүүлж, ашигт ажиллагаа нэмэгдүүлснээр компанийн нийт хөрөнгө **13.4 их наяд** , **355.2 тэрбум** төгрөгийн өр төлбөр, **13 их наяд** төгрөгийн өөрийн хөрөнгөтэй байна. Компанийн нийт хөрөнгийн 8%-ийг эргэлтийн хөрөнгө, 92%-ийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна.

- Харин 2020 оны байдлаар **14.2 их наяд** төгрөгийн нийт хөрөнгөтэй, 2 их наяд төгрөгийн өр төлбөр, 12 их наяд төгрөгийн өөрийн хөрөнгөтэй байна. Компанийн нийт хөрөнгийн 9%-ийг эргэлтийн хөрөнгө, 91%-ийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна.

| **Санхүүгийн байдлын тайлан** (тэрбум төгрөг) | 2018A | 2019A | 2020A | 2021E |
|---|---|---|---|---|
| Эргэлтийн хөрөнгө | 784 | 1,040 | 1,205 | 1,762 |
| Эргэлтийн бус хөрөнгө | 11,541 | 12,345 | 12,956 | 14,279 |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **12,325** | **13,385** | **14,161** | **16,041** |
| **Богино хугацаат өр төлбөр** | 285 | 312 | 1,996 | 1,429 |
| Урт хугацаат өр төлбөр | 36 | 43 | 55 | 2,055 |
| Нийт өр төлбөрийн дүн | 321 | 355 | 2,051 | 3,484 |
| Эздийн өмчийн дүн | 12,004 | 13,030 | 12,110 | 12,557 |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **12,325** | **13,385** | **14,161** | **16,041** |

*Эх сурвалж: Компанийн санхүүгийн тайлан*

| **Орлогын тайлан** (тэрбум төгрөг) | 2018A | 2019A | 2020A | 2021E |
|---|---|---|---|---|
| Борлуулалтын орлого | **1,987** | **2,661** | **1,548** | **2,673** |
| Борлуулалтын өртөг | **681** | **696** | **673** | **699** |
| **Нийт ашиг (алдагдал)** | **1,306** | **1,965** | **875** | **1,974** |
| *Нийт ашгийн харьцаа* | *66%* | *74%* | *57%* | *74%* |
| **ХТЭХӨА** | **1,132** | **1,409** | **309** | **840** |
| *ХТЭХӨА-н харьцаа* | *57%* | *53%* | *20%* | *31%* |
| **Цэвэр ашиг** | **808** | **1,036** | **162** | **514** |
| *Цэвэр ашгийн харьцаа* | *41%* | *39%* | *10%* | *19%* |

*Эх сурвалж: Компанийн санхүүгийн тайлан*

- Компани 2018 онд 13.1 сая тонн нүүрс борлуулж, 1.99 их наяд төгрөгийн борлуулалтын орлого олсон нь өмнөх оноос **68%-иар** өссөн.

- 2019 онд 2.66 их наяд төгрөгийн борлуулалтын орлого, 1 их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, Монгол Улсдаа анх удаа **НЭГ ТЭРБУМ** ам.долларын борлуулалтын орлоготой компани болсон.

- 2017-2018 онд компани өр зээлээ бүрэн төлж барагдуулсан.

- Компанийн ерөнхий үзүүлэлтүүд 2018, 2019 онд харьцангуй өндөр байсан бол 2020 онд Коронавирус цар тахлын нөлөөгөөр буурсан ч цаг үеийн нөхцөл байдлын өөрчлөлтөөс хамааралтай худалдааны хориг, хязгаарлалтууд тавигдан нөхцөл байдал хэвийн үргэлжилснээр компанийн үзүүлэлтүүд тогтворжих төлөвтэй байна.

## САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

*Компанийн ашигт ажиллагааны үзүүлэлтүүд*




- Төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт, Цанхийн уурхайн уулын техникийн нөхцөл байдлаас шалтгаалж 2021-2025 онд компани нь 3, 4-р давхраасын сайн чанарын коксжих нүүрс, 0, 5, 7, 8, 9-р давхраасуудын зөөлөн коксжих чанартай нүүрс, исэлдсэн нүүрс болон баяжуулсан нүүрсийг зах зээлд нийлүүлнэ.
- Нүүрс баяжуулах үйлдвэрийн эхний 10 сая.тн хүчин чадалтай модуль нь 2024 оноос ашиглалтад орно. Баяжуулсан нүүрсний хувьд эхний жилдээ 3, 4, 5-р давхраасуудын хатуу коксжих нүүрс 0, 1, 2-р давхраасуудын зөөлөн коксжих нүүрсийг боловсруулах ба цаашид 7, 8, 9, 10-р давхраасуудын зөөлөн коксжих нүүрс, исэлдсэн нүүрсийг угаах үйлдвэрт боловсруулж, зах зээлд нийлүүлнэ.
- Бортээг уурхайгаас олборлох нүүрсийг 2021 оноос хуурай баяжуулах технологиор, 2024 оноос нүүрс баяжуулах үйлдвэрт боловсруулж, зах зээлд нийлүүлнэ. Зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан тооцсон жигнэсэн дундаж үнээр 2021-2025 онд компани нь 33.6 их наяд төгрөгийн орлоготой ажиллана.

| № | Үзүүлэлт | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Олборлолт, сая тонн | 22 | 29 | 37 | 48 | 50 | **199** |
| 2 | Борлуулалт, сая тонн | 21 | 28 | 33 | 43 | 47 | **184** |
| 3 | Орлого, тэрбум төгрөг | 2,673 | 4,663 | 7,036 | 9,165 | 10,055 | **33,592** |
| 4 | Үйл ажиллагааны зардал, тэрбум төгрөг | 1,835 | 2,536 | 3,339 | 4,603 | 4,971 | **17,284** |
| 5 | Улсын төсөвт төвлөрүүлэх татвар, тэрбум | 603 | 1,083 | 1,680 | 2,070 | 2,324 | **7,761** |
| 6 | Хүү, татвар, элэгдэл хорогдлын өмнөх ашиг (EBITDA) | 840 | 2,091 | 3,661 | 4,522 | 5,055 | **16,169** |
| | *ХТЭХӨА-ийн харьцаа* | *31.4%* | *44.8%* | *52.0%* | *49.3%* | *50.3%* | ***48.1%*** |
| 7 | **Цэвэр ашиг, тэрбум төгрөг** | 514 | 1441 | 2602 | 3237 | 3,735 | **11,528** |
| | *Цэвэр ашгийн харьцаа* | *19%* | *31%* | *37%* | *35%* | *37%* | ***31.9%*** |
| | **Ногдол ашиг, тэрбум төгрөг** | - | - | (283) | (496) | (617) | **7** |

*Эх сурвалж: Компанийн бизнес төлөвлөгөө*

# **БОНДЫН ТУХАЙ** БОНДЫН НӨХЦӨЛ

ЭТТ-БОНД

| | **ТӨГРӨГИЙН** БОНД | | **ДОЛЛАРЫН** БОНД | |
|---|---|---|---|---|
| **Захиалгын Арга** | Захиалга бүртгэлийн арга | Дуудлага бүртгэлийн арга | Захиалга бүртгэлийн арга | Дуудлага бүртгэлийн арга |
| Нэгж бондын үнэ | 100,000 төг | | 100 ам.доллар | |
| Бондын хүү | 10% хүртэл | | 6.8% хүртэл | |
| Бондын хугацаа | 24 сар | | 24 сар | |
| Хүү төлөх хугацаа | Хагас жил тутам | | Хагас жил тутам | |
| Нийт тоо ширхэг | **1,200,000 ширхэг** | | **1,684,210 ширхэг** | |
| Боломжит тоо ширхэг | 350,000 ширхэг | 850,000 ширхэг | 300,000 ширхэг | 1,384,210 ширхэг |
| Захиалгын дээд хэмжээ | 2 тэрбум төгрөгөөс доош | 1 тэрбум төгрөгөөс дээш | 1 сая доллароос доош | 500 мянган доллароос дээш |
| Баталгаа | Борлуулалтын орлого | | Борлуулалтын орлого | |
| Ханшийн өөрчлөлтийн хязгаар | 0.05% | | 0.05% | |
| Орлогын татвар | Хувь хүн – 5%<br>АНН – 10% | | Хувь хүн – 5%<br>АНН – 10% | |
| **Захиалга шивэх өдөр** | **2021/03/30-2021/04/02** | **2021/04/02** | **2021/03/30-2021/04/02** | **2021/04/02** |
| Цаг | 10:00-17:00 | 10:00-12:00 | 10:00-17:00 | 13:00-15:00 |

**БОНДЫН** ОНЦЛОГ

- ЭТТ нь өр төлбөр барагдуулах чадвар өндөр
- Хамгийн анхны **төгрөг** болон **ам.доллар**ын хосолсон бонд
- Бүх хөрөнгө оруулагчдад **нээлттэй** - Гадаад, дотоодын иргэд, аж ахуй нэгжүүд, арилжааны банкууд, даатгалын компаниуд, хөрөнгө оруулалтын сангууд гэх мэт
- Долларын бондын хүү нь арилжааны банкуудын ам.долларын хадгаламжийн дундаж хүүгээс **(2%)** өндөр
- Монгол улсын засгийн газрын “Номад” бондын өгөөж 3%-аас өндөр хүүтэй

# БОНД ГАРГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР ТӨЛӨХ ЧАДВАРЫН ШИНЖИЛГЭЭ

## МӨНГӨН УРСГАЛЫН ШИНЖИЛГЭЭ




*Эх сурвалж: Компанийн бизнес төлөвлөгөө*

## КОМПАНИЙН ЗЭЭЛЖИХ ЧАДВАР




*Эх сурвалж: Компанийн бизнес төлөвлөгөө*

## САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| *Жил* | *2020A* | *2021E* | *2022E* | *2023E* | *2024E* | *2025E* |
|---|---|---|---|---|---|---|
| **Өрийн харьцаа** | | | | | | |
| Өр/ХТЭХӨА (Debt/EBITDA) | 1.83 | 2.38 | 1.24 | 0.34 | 0.07 | 0.06 |
| Өр/Эздийн өмч (Debt/Equity) | 5% | 16% | 19% | 7% | 2% | 1% |
| Өр төлөх чадварын харьцаа | 0.40 | 1.09 | 5.92 | 2.24 | 3.46 | |
| **Ашгийн харьцаа** | | | | | | |
| EBITDA харьцаа | 20% | 31% | 45% | 52% | 49% | 50% |
| Цэвэр ашгийн харьцаа | 17% | 19% | 31% | 37% | 35% | 37% |
| ROE | 1.3% | 4% | 9% | 15% | 16% | 15% |

*Эх сурвалж: Компанийн санхүүгийн тайлан*

***Компанийн ирээдүйн мөнгөн урсгал өр төлбөрөө барагдуулах чадвар хангалттайг харуулж байна.***

# БОНД ГАРГАГЧИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ

**Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт**

| | | |
|---|---|---|
| **972.7** тэрбум төгрөг /хүртэлх/ — **Дэд бүтцийн төслүүд** | **371** тэрбум төгрөг /хүртэлх/ — **Уурхайн хөгжүүлэлт** | **650.6** тэрбум төгрөг /хүртэлх/ — **Эргэлтийн хөрөнгө** |
| **48%** | **19%** | **33%** |

**ТЭРГҮҮЛЭХ ЭЭЛЖИЙН ЗАРЦУУЛАЛТ**

ЭТТ нь бондын тэргүүн ээлжийн зарцуулалтыг Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл, компанийн эргэлтийн хөрөнгө, холболтын төмөр зам, олборлолтын техник тоног төхөөрөмжийн худалдан авалт болон нүүрс ачилтын байгууламжид байршуулна.

ЭТТ нь 2021 онд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл, 2022 онд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөл болон холболтын төмөр замын төслийг тус тус ашиглалтад оруулж, 2021-2022 онд нүүрс ачилтын байгууламжийн тодорхой хэсгийг гүйцэтгэснээр 2021-2024 онуудад 135.6 сая тонн нүүрс олборлож, 125.8 сая тонн нүүрс борлуулж, нийт 7,662 сая ам.долларын борлуулалтын орлоготой, 2,521 сая ам.долларын цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөж байна.

Иймд эдгээр төслүүд нэн тэргүүнд хэрэгжих нь бондын эргэн төлөлтийн үеийн буюу 2021-2024 оны мөнгөн урсгалд гол үр нөлөө үзүүлэх, компанийн орлого ашгийн үзүүлэлтийг нэмэгдүүлснээр өөрийн мөнгөн урсгалаар бусад төслүүдийн санхүүжилтийг хэрэгжүүлэх боломж олгох зэрэг чухал ач холбогдолтой.

| | Зориулалт | Мөнгөн дүн |
|---|---|---|
| **Дэд бүтцийн төслүүд** | ➢ Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн үлдэгдэл санхүүжилт | 601.1 тэрбум төгрөг |
| | ➢ Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын холбох холботын төмөр замын санхүүжилт ($75.2 сая-ийн 30%) | 65.4 тэрбум төгрөг |
| | ➢ 450 МВт-ын хүчин чадалтай Тавантолгойн дулааны цахилгаан станцын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт ($105.6 сая) | 306.2 тэрбум төгрөг |
| | **Нийт** | **972.7 тэрбум төгрөг** |
| **Уурхайн хөгжүүлэлт** | ➢ Олборлолтын техник, тоног төхөөрөмж худалдан авах хөрөнгө оруулалт<br>➢ Төмөр замд нүүрс ачих байгууламжийн бүтээн байгуулалтын санхүүжилт ($75.0 сая-ийн 30%)<br>➢ Өмнөговь аймгийн Цогтцэций, Цогт-Овоо сумдын нутагт орших "Загийн усны хоолой" гүний усны ордоос ус татах шугам хоолойн бүтээн байгуулалтын санхүүжилтын урьдчилгаа<br>➢ Нүүрс баяжуулах үйлдвэрийн эхний 10 сая тонны блокын санхүүжилтийн 16% ($42.6 сая)<br>➢ Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших “Цагаанцав”-ын гүний усны ордоос ус татах шугам хоолойн бүтээн байгуулалтын санхүүжилтын урьдчилгаа | Төслийн гүйцэтгэл (2020 оны эцсийн байдлаар):<br>▪ 416.1 км үндсэн замын гүйцэтгэл: доод бүтцийн ажил 100.0%, дээд бүтцийн ажил 54.9%, 228.5 км төмөр зам тавьсан. |
| | **Нийт** | **371.0 тэрбум төгрөг** |
| **Эргэлтийн хөрөнгө** | ➢ Гэрээт олборлогчдын өгөх өглөг<br>➢ Өрийн бүтцийн шинэчлэлт | 320.6 тэрбум төгрөг<br>330.0 тэрбум төгрөг |
| | **Нийт** | **650.6 тэрбум төгрөг** |

# **БОНД ГАРГАГЧИЙН** ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

## Дэлхийн коксжих нүүрсний эрэлт, нийлүүлэлт, балансын таамаглал 2021-2025

- Дэлхийн коксжих нүүрсний хэрэглээ 2020 онд 1.021 тэрбум.тн байсан бол 2021 онд 4% орчим өсөж **1,061 сая.тн** болох төлөвтэй байна.
- БНХАУ-ын нүүрсний салбарын томоохон судалгааны байгууллага болох "Фенвэй Энержи"-ийн үзэж байгаагаар дэлхийн коксжих нүүрсний эрэлт жилд ойролцоогоор 2% орчим өсөх төлөвтэй байна.
- 2025 онд дээд цэгтээ буюу **1,065.2 сая.тн**-д хүрэх бол урт хугацаанд аажмаар буурч 1,000 сая.тн-ын түвшинд хадгалагдана гэж тооцоолжээ.

*Дэлхийн коксжих нүүрсний эрэлт нийлүүлэлтийн таамаглал (сая тонн)*




*Эх сурвалж: Фенвэй Энержи*

## ЭТТ дэлхийн зах зээлд эзлэх байр суурь

- "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн мэдэлд байдаг Тавантолгой бүлэг орд коксжих нүүрсний арвин их нөөцтэй.
- Дэлхийн коксжих нүүрсний худалдаа 2019 онд 292.9 сая тонн байснаас 15 сая тонныг ЭТТ компанийн экспорт дангаараа бүрдүүлсэн бол 2021 онд 7%-ийг, 2023 буюу 5.1%-онд 10.3%-ийг бүрдүүлэх зорилт тавин ажиллаж байна.
- Ингэснээр үнэт цаас гаргагч нь коксжих нүүрсний худалдаа эрхэлдэг дэлхийн топ 10 компанийн нэг болох боломжтой.
- Зорилтот зах зээл болох БНХАУ нь 2019 онд нийт 73 сая коксжих нүүрс импортолсноос 20.3 хувийг нь ЭТТ-н экспорт бүрдүүлсэн. Цаашид ЭТТ нь энэхүү үзүүлэлтийг ахиулж 2025 он гэхэд 60%-д хүргэхээр төлөвлөсөн.

*Дэлхийн коксжих нүүрсний худалдаа ба ЭТТ-н эзлэх хувь (сая тонн)*




*Эх сурвалж: Компанийн бизнес төлөвлөгөө*

*2019 онд "Эрдэнэс Тавантолгой" ХК нь коксжих нүүрс олборлолтын хэмжээгээр Ази тивд 12-т үнэлэгдэж байсан бол*

*2025 онд **"Топ-5"-д** буюу 4 дүгээр байранд орохоор зорьж байна.*

# **БОНД ГАРГАГЧИЙН** БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ 2021-2025 ОН




*Эх сурвалж: Компанийн бизнес төлөвлөгөө*

*Дээрх бүтээн байгуулалтууд нь ЭТТ-г*
***Дэлхийн нүүрсний салбарын тэргүүлэгч** болох боломжийг бүрдүүлэх юм.*

## **ТӨСЛИЙН ХЭРЭГЖИХ ҮЕ ШАТ**

- **2021 онд** Цанхи, Бортээгээс олборлосон нүүрсний тодорхой хэсгийг Тавантолгой- Зүүнбаян чиглэлийн төмөр замаар тээвэрлэнэ.
- **2022 онд** Цанхи, Бортээгээс олборлосон нүүрсийг чанараар ангилан Нүүрс ачилтын байгууламжид хүргэн, нэгдсэн байдлаар Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой Гашуунсухайт гэсэн 2 өөр чиглэлийн төмөр замаар тээвэрлэнэ.
- **2023 онд** Загийн усны хоолойн төсөл бүрэн хэрэгжиж Нүүрс баяжуулах үйлдвэрийн бэлтгэл ажил, усны асуудал шийдэгдэнэ.
- **2024 онд** Нүүрс баяжуулах үйлдвэр ашиглалтад орж, Цанхи, Бортээгийн нүүрсийг нэмүү өртөг шингээн боловсруулж, 10 сая.тн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.
- **2024 онд** Цанхийн баруун хөрсний 3-р овоолго үүсэж, тус бүр 8.9-9.1 км урт 2 шугамтай, жилийн 100 сая м3 тээвэрлэх хүчин чадал бүхий конвейерийн систем нэвтэрсэн байна.
- **2024 онд** Нүүрс ачилтын төвөөс Нүүрс баяжуулах үйлдвэр хүртэл 12.6 км зайнд жилийн 100 сая.тн нүүрс тээвэрлэх хүчин чадал бүхий конвейерийн систем уурхайн олборлолтын үйл ажиллагаатай уялдан нэвтэрсэн байна.

# БОНД ГАРГАХАД ОРОЛЦСОН ЭТГЭЭДИЙН ТУХАЙ

| Оролцогч | Байгууллага | Холбоо барих |
|---|---|---|
| Тэргүүлэх андеррайтер | БиДиСЕК ҮЦК ХК | Хаяг: "БиДиСЕК ҮЦК" ХК-ийн байр, Залуучуудын өргөн чөлөө 27/1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс<br>Утас: (976) 7555-1919<br>Вэбсайт: www.bdsec.mn |
| Дэд андеррайтер, санхүүгийн зөвлөх | MICC | Хаяг: Улаанбаатар 15170, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Явуухулангийн цэцэрлэг, JJ Тауэр, 7-р давхар<br>Утас: (976) 7011-2023<br>Вэбсайт: www.micc.mn |
| Хуулийн зөвлөх | B&P BATBAYAR AND PARTNERS LLP | Хаяг: 10-р давхар, 1001-1003 тоот, Монгол ТВ цамхаг, 14253 Чингисийн өргөн чөлөө-8, 1-р хороо, Сүхбаатар дүүрэг<br>Утас: + 976 7611 9007<br>Вэбсайт: www.bnp.mn |
| Хараат бус үнэлгээ | BDO | Хаяг: 1502 тоот, 15-р давхар, Юнион бюлдинг B-блок, Нарны зам-62, 1-р хороо, ЮНЕСКО-гийн гудамж, СБД<br>Утас: (976) 7740-4040, 7740-4041<br>Вэбсайт: www.bdo.mn |
| Аудит | ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР | Хаяг: Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар-15160, Монгол Улс<br>Утас: 51-263813<br>Вэбсайт: www.audit.mn |

# ХАВСРАЛТ: БОНД ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## БОРЛУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, НҮҮРСНИЙ ТӨРЛӨӨР

| | 2021E | 2022E | 2023E | 2024E | 2025E | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| Нийт борлуулалт | 100% | 100% | 100% | 100% | 100% | 100% |
| Хатуу коксжих | 70% | 62% | 41% | 43% | 20% | 14% |
| Бусад давхраас | 29% | 30% | 42% | 44% | 46% | 55% |
| Исэлдсэн /эрчим хүчний нүүрс | 2% | 3% | 4% | 4% | 4% | 4% |
| Баяжмал /Хуурай, нойтон/ | 0% | 4% | 9% | 6% | 25% | 24% |
| Завсрын нүүрс /Хуурай, нойтон/ | 0% | 1% | 4% | 2% | 4% | 4% |




*Эх сурвалж: Компанийн санхүүгийн тайлан*

## БОРЛУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, БАЙРШЛААР




*Эх сурвалж: Компанийн санхүүгийн тайлан*

- Компанийн 2021-2025 оны дэд бүтцийн төслүүд хэрэгжсэнээр жилд **50 сая.тонн нүүрс** олборлож, борлуулах суурь нөхцөл, техникийн үзүүлэлтүүд бүрдэхээс гадна төмөр замын бүтээн байгуулалтын хүрээнд тээврийн зардлыг үлэмж бууруулах, гуравдагч улсуудын зах зээлд нүүрс борлуулах боломж бүрдэх юм.
- Мөн баяжуулах үйлдвэр ашиглалтад орсноор, голчлон 3 болон 4-р давхраанаснуудад олборлолт хийгддэг байдлыг зогсоож, ордын зохистой ашиглалтыг бүрдүүлэхээс гадна бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээнэ.

# ХАВСРАЛТ: БОНД ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ

## Уурхайн ажлын төлөвлөгөө

| ҮЗҮҮЛЭЛТ | | 2021 ОН | 2022 ОН | 2023 ОН | 2024 ОН | 2025 ОН | НИЙТ |
|---|---|---|---|---|---|---|---|
| **УУЛЫН НИЙТ АЖИЛ** | | | | | | | |
| Хөрс хуулалт | мян.м3 | 107,794 | 137,672 | 167,234 | 204,879 | 224,908 | **842,488** |
| Нүүрс олборлолт | мян.тн | 22,044 | 29,044 | 37,125 | 47,504 | 50,378 | **186,095** |
| Уулын цул | мян.м3 | 123,540 | 158,418 | 193,752 | 238,811 | 260,892 | **975,413** |
| Хөрс хуулалтын коэффициент | м3/тн | 4.9 | 4.7 | 4.5 | 4.3 | 4.5 | **4.5** |
| **ЦАНХИЙН ЗҮҮН** | | | | | | | |
| Хөрс хуулалт | мян.м3 | 57,600 | 57,600 | 57,600 | 72,000 | 72,000 | **316,800** |
| Нүүрс олборлолт | мян.тн | 12,000 | 12,000 | 12,000 | 15,000 | 15,000 | **66,000** |
| Уулын цул | мян.м3 | 66,171 | 66,171 | 66,171 | 82,714 | 82,714 | **363,943** |
| Хөрс хуулалтын коэффициент | м3/тн | 4.8 | 4.8 | 4.8 | 4.8 | 4.8 | **4.8** |
| **ЦАНХИЙН БАРУУН** | | | | | | | |
| Хөрс хуулалт | мян.м3 | 44,000 | 66,000 | 82,500 | 93,500 | 110,317 | **396,317** |
| Нүүрс олборлолт | мян.тн | 8,000 | 12,000 | 15,000 | 17,000 | 20,058 | **72,058** |
| Уулын цул | мян.м3 | 49,714 | 74,571 | 93,214 | 105,643 | 124,644 | **447,787** |
| Хөрс хуулалтын коэффициент | м3/тн | 5.5 | 5.5 | 5.5 | 5.5 | 5.5 | **5.5** |
| **БОР ТЭЭГ** | | | | | | | |
| Хөрс хуулалт | мян.м3 | 6,194.4 | 14,072.4 | 27,134.3 | 39,379.3 | 42,591.0 | **129,371** |
| Нүүрс олборлолт | мян.тн | 2,044.4 | 5,043.9 | 10,124.7 | 15,503.7 | 15,320.5 | **48,037** |
| Уулын цул | мян.м3 | 7,654.7 | 17,675.1 | 34,366.2 | 50,453.4 | 53,534.2 | **163,684** |
| Хөрс хуулалтын коэффициент | м3/тн | 3.0 | 2.8 | 2.7 | 2.5 | 2.8 | **2.7** |

# ХАВСРАЛТ: БОНД ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

## Борлуулалтын орлого, байршлаар

| | | 2021(f) | 2022(f) | 2023(f) | 2024(f) | 2025(f) | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Нийт борлуулалтын хэмжээ** | **сая. тн** | **21.12** | **28.02** | **33.18** | **43.41** | **46.91** | **172.64** |
| Баруун Цанхи | сая. тн | 7.67 | 12.00 | 13.24 | 16.78 | 19.80 | 69.49 |
| Зүүн Цанхи | сая. тн | 11.64 | 11.80 | 11.46 | 13.28 | 13.94 | 62.12 |
| Бортээг | сая. тн | 1.81 | 4.22 | 8.48 | 13.35 | 13.17 | 41.04 |
| | | | | | | | |
| **Жигнэсэн дундаж үнэ, $** | **$/тн** | **43.64** | **55.72** | **68.91** | **66.62** | **65.67** | |
| Баруун Цанхи | $/тн | 46.41 | 59.24 | 75.29 | 72.35 | 71.53 | |
| Зүүн Цанхи | $/тн | 43.44 | 57.80 | 74.81 | 71.85 | 69.73 | |
| Бортээг | $/тн | 33.20 | 39.87 | 51.00 | 54.23 | 52.57 | |
| | | | | | | | |
| **Нийт борлуулалтын орлого, сая $** | **сая $** | **921.7** | **1,561.1** | **2,286.8** | **2,892.3** | **3,080.5** | **10,742.4** |
| Баруун Цанхи | сая $ | 356 | 710.9 | 996.8 | 1,214.1 | 1,416.0 | 4,693.8 |
| Зүүн Цанхи | сая $ | 506 | 682.0 | 857.3 | 954.1 | 972.1 | 3,971.1 |
| Бортээг | сая $ | 60 | 168.2 | 432.7 | 724.1 | 692.4 | 2,077.5 |
| | | | | | | | |
| **Нийт борлуулалтын орлого, сая ₮** | **сая ₮** | **2,673** | **4,663** | **7,036** | **9,165** | **10,055** | **33,592** |
| Баруун Цанхи | сая ₮ | 1,032.27 | 2,123.56 | 3,066.83 | 3,847.32 | 4,621.77 | 14,692 |
| Зүүн Цанхи | сая ₮ | 1,466.21 | 2,037.09 | 2,637.64 | 3,023.45 | 3,172.95 | 12,337 |
| Бортээг | сая ₮ | 174.33 | 502.48 | 1,331.18 | 2,294.64 | 2,259.86 | 6,562 |

## Үйл ажиллагааны зардлын задаргаа

| | | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| Цанхийн баруун уурхайн хувьсах зардал | сая ₮ | 665,154.2 | 1,006,796.8 | 1,278,300.1 | 1,609,399.0 | 1,895,132.1 | **6,454,782.2** |
| Цанхийн зүүн уурхайн хувьсах зардал | сая ₮ | 918,402.3 | 928,593.7 | 967,974.8 | 1,248,622.5 | 1,253,632.8 | **5,317,226.1** |
| Бортээгийн уурхайн хувьсах зардал | сая ₮ | 132,218.5 | 311,445.1 | 634,572.2 | 961,352.2 | 999,500.5 | **3,039,088.6** |
| Баяжуулах зардал | сая ₮ | - | - | - | 174,290.0 | 179,518.7 | **353,808.6** |
| Үйл ажиллагааны тогтмол зардал | сая ₮ | 119,488.5 | 129,226.8 | 139,758.8 | 151,149.1 | 163,467.8 | **703,091.1** |
| Төмөр замын тээвэрлэлтийн зардал | сая ₮ | - | 159,896.0 | 318,678.5 | 458,119.2 | 479,214.2 | **1,415,907.8** |
| **Үйл ажиллагааны зардал** | сая ₮ | **1,835,263.5** | **2,535,958.4** | **3,339,284.3** | **4,602,932.0** | **4,970,466.0** | **17,283,904.3** |

- Компанийн нийт зардлын дунджаар **75 хувийг** гэрээт олборлогчийн зардал эзэлж байна.
- Компанийн үйл ажиллагааны тогтмол зардал нийт зардлын **4.3 хувийг** эзэлж байна.
- 2023 оноос баяжуулах үйлдвэрийн үйлдвэрлэл, төмөр замын тээвэрлэлт тогтворжиж зардлын зүйл өснө.

# ХАВСРАЛТ: БОНД ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ

## Улсын төсөвт бүрдүүлэх татварын хэмжээ

| Д/д | Татварын төрөл | Хэмжих нэгж | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | ААНОАТатвар | сая ₮ | 171,372.54 | 480,213.54 | 867,221.65 | 1,078,841.87 | 1,244,866.06 | 3,842,515.65 |
| 2 | Агаарын бохирдлын төлбөр | сая ₮ | 22,044.37 | 29,043.86 | 37,124.73 | 47,503.67 | 50,378.11 | 186,094.74 |
| 3 | АМНАТөлбөр | сая ₮ | 336,554.15 | 485,141.69 | 670,258.58 | 816,759.78 | 891,460.19 | 3,200,174.40 |
| 4 | Гаалийн хураамж | сая ₮ | 35,270.99 | 46,470.17 | 59,399.57 | 76,005.87 | 80,604.98 | 297,751.58 |
| 5 | Ус ашигласны төлбөр | сая ₮ | 1,019.61 | 1,155.22 | 1,308.87 | 1,482.95 | 1,680.18 | 6,646.83 |
| 6 | Газрын төлбөр | сая ₮ | 1,753.98 | 1,806.60 | 1,860.79 | 1,916.62 | 1,974.12 | 9,312.10 |
| 7 | ҮХХАТатвар | сая ₮ | 27.61 | 29.86 | 32.30 | 34.93 | 37.78 | 162.47 |
| 8 | АТӨЯХАТатвар | сая ₮ | 16,534.35 | 17,881.90 | 19,339.27 | 20,915.43 | 22,620.03 | 97,290.98 |
| 9 | Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хураамж | сая ₮ | 496.42 | 511.31 | 526.65 | 542.45 | 558.72 | 2,635.55 |
| 10 | ХХОАТатвар | сая ₮ | 4,854.95 | 5,500.66 | 6,232.25 | 7,061.14 | 8,000.27 | 31,649.27 |
| 11 | НДШимтгэл | сая ₮ | 13,296.02 | 15,064.39 | 17,067.96 | 19,337.99 | 21,909.95 | 86,676.31 |
| | **НИЙТ ДҮН** | | **603,225.00** | **1,082,819.20** | **1,680,372.62** | **2,070,402.69** | **2,324,090.38** | **7,760,909.89** |

# ХАВСРАЛТ: БОНД ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

## Үйл ажиллагааны мөнгөн урсгалын задаргаа

| | | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Хүү, татвар, элэгдэл хорогдлын өмнөх ашиг /EBITDA/** | **сая ₮** | **837,540.7** | **2,127,179.7** | **3,696,368.3** | **4,562,480.0** | **5,084,120.5** | **16,307,689.1** |
| *EBITDA түвшин* | | *31%* | *46%* | *53%* | *50%* | *51%* | *46%* |
| Элэгдэл, хүүгийн зардал | сая ₮ | 40,983.9 | 46,829.9 | 63,909.7 | 78,240.7 | 95,792.0 | 325,756.18 |
| **Хүү, татварын өмнөх ашиг /EBIT/** | **сая ₮** | **796,556.8** | **2,080,349.8** | **3,632,458.6** | **4,484,239.2** | **4,988,328.5** | **15,981,932.9** |
| Хүүгийн зардал /Арилжааны банк/ | сая ₮ | 111,063.1 | *158,087.2* | *155,537.9* | *163,055.7* | - | 587,743.8 |
| **Татварын өмнөх ашиг** | **сая ₮** | **685,493.7** | **1,922,262.6** | **3,476,920.7** | **4,321,183.6** | **4,988,328.5** | **15,394,189.1** |
| ААНОАТ+лицензийн төлбөр+татварын өр | сая ₮ | 171,372.5 | 480,565.7 | 869,230.2 | 1,080,295.9 | 1,247,082.1 | 3,848,546.4 |
| **ЦЭВЭР АШИГ** | **сая ₮** | **514,121.2** | **1,441,697.0** | **2,607,690.5** | **3,240,887.7** | **3,741,246.3** | **11,545,642.7** |
| *Цэвэр ашгийн түвшин* | | *19%* | *31%* | *37%* | *35%* | *37%* | *34%* |
| **Үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгал** | **сая ₮** | **555,105.1** | **1,488,526.8** | **2,671,600.2** | **3,319,128.4** | **3,837,038.3** | **11,871,398.9** |